



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/144

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монголросцветмет" ХХК-ийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс аймгийн Засаг даргад холбогдуулан Хэнтий аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.1.4, 25.1.5, 25.1.6, 25.1.7, 25.1.8 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын уул уурхай хариуцсан мэргэжилтэн Г.Мөнх-Эрдэнэ нарт олгож өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Засаг даргыг төлөөлж оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын уул уурхай хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнх-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 02 сарын 03-ны А/37 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 693